

Хичээл №9

# Үндсэн хууль



1-р сарын 13  
Үндсэн хуулийн өдөр

Багш: Өглөөний мэнд, хүүхдүүд ээ!  
За өнөөдөр хэдэн сарын хэдэн бэ?  
Ямар тэмдэглэлт өдөр билээ?

Сийлэн: Өнөөдөр 1 сарын 13-ны өдөр.  
Багш: Өнөөдөр Үндсэн хуулийн өдөр.

Багш аа, Үндсэн хуулийн  
өдрийг яагаад тэмдэглэдэг  
вэ?



Манай улс 1990 оны Ардчилсан хувьсгалын дараа Үндсэн хуулиа шинэчлэх ажлыг эхлүүлжээ.

Үндсэн хуулийн төслийн талаар ард түмнээсээ 3 сарын турш санал авч, парламентаар 4 сарын турш хэлэлцсэн түүхтэй.

Монгол Улсын Ардчилсан шинэ Үндсэн хуулийг 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр баталсан.


Манай улсын  
Үндсэн хууль Оршил,  
6 бүлэг,  
70 зүйлтэй.

1992 оны 1-р сарын 13



Нэгдүгээр сарын 13-ны өдөр манай  
улсын амин чухал хууль болох Үндсэн  
хуулийн мэндэлсэн өдөр учраас бид  
энэ өдрийг Үндсэн хуулийн өдөр  
хэмээн тэмдэглэдэг.






Үндсэн хууль тийм чухал хууль юм уу?  
Яагаад бусад хууль түүнд нийцэж байх ёстой гэж?

Манай улсын парламент буюу Улсын Их Хурлаас иргэн бүр дагаж мөрдөх ёстой хуулиудыг батлан гаргадаг. Энэ хуулиуд нь Монгол улсаа хөгжүүлж, иргэдийг аз жаргалтай, сайн сайхан, аюулгүй амьдруулахад чиглэсэн байна.

Харин Үндсэн хууль бол эдгээр хуулиудаас хамгийн дээд хүчин чадалтай хууль юм. Учир нь бусад бүх хууль Үндсэн хуульд нийцэж байх ёстой бөгөөд Үндсэн хууль нь бусад хуулиудын эх сурвалж болдог.



Манай улс Үндсэн хуульдаа дараах үнэт зүйлээ хамгаалахаар тусгасан байдаг. Үүнд:

1. Манай улс бүрэн эрхтэй, тусгаар тогтносон, бүгд найрамдах улс болох тухай;
2. Хүний эрх, эрх чөлөөний тухай;
3. Төрийн дээд байгууллагуудын тухай;
4. Монгол Улс нийслэл, хот, аймаг, сум, багт хуваагддаг тухай гэх мэт.

Үндсэн хуулиас бусад хууль урган гардаг. Тухайлбал, Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 7 дахь хэсэгт "Хүн бүр сурч боловсрох эрхтэй" гэсэн заалтад тулгуурлан Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль батлагджээ.

Үндсэн хуульд нийцээгүй ямар ч хууль гаргаж болохгүй. Жишээ нь, Үндсэн хуулиар заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн ямар ч хууль хүчингүй.



Бидний эрх, эрх чөлөөг Үндсэн хуулиар хамгаалсан байдаг.

Хууль Үндсэн хуульд нийцэж байх ёстой.

Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн ямар ч хууль хүчингүй.

Аан, ийм учраас Үндсэн хуулийг хүний эрх, эрх чөлөөний баталгаа, үндэс болсон гол хууль гэдэг юм байна шүү дээ.

Бусад хуулийн үндэс болдог учраас Үндсэн хууль гэж нэрлэсэн юм.



Үндсэн хууль нь ард түмний гол хууль юм.  
Үндсэн хуулийг батлахдаа иргэдийн  
саналыг авдаг.

Ийм учраас Монгол Улсын Үндсэн хууль  
"Монголын Ард түмэн бид..." гэж эхэлсэн  
байдаг.







ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

1992 оны 1 дүгээр сарын  
15-ны өдөр Ерөнхийлөгч  
Үндсэн хуулийн эх дээр  
гарын үсэг зуржээ.

Уг эхийг одоо  
Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
албан өрөөнд  
хадгалдаг.



## ТҮЛХҮҮР ҮГ

ҮНДСЭН  
ХУУЛЬ

ХУУЛЬ

ЭРХ  
ЧӨЛӨӨ

ХҮНИЙ  
ЭРХ

Найзууд аа! Эдгээр түлхүүр үгийн утгыг өөрийн үгээр тайлбарлаж чадаж байвал чихчээлээ маш сайн ойлгожээ гэсэн үг шүү.



## ДАСГАЛ АЖИЛ

Дасгалын хуудсан дээр Монгол Улсын Үндсэн хуулийн талаар өөрийн олж мэдсэн зүйлийг бичнэ үү.



## ХЯНАЛТЫН АСУУЛТ

1. Үндсэн хууль гэж юу вэ?
2. Үндсэн хуулийг яагаад "Ард түмний гол хууль" гэж нэрлэдэг вэ?
3. Яагаад Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэдэг вэ?
4. Үндсэн хуулийг тооны хэлээр илэрхийлнэ үү? Тухайлбал, хэдэн бүлэг, зүйлтэй, хэзээ батлагдсан...гэх мэт